

**МОНГОЛ-ТУВА БИЧГИЙН ХЭЛНИЙ ДУНДЫН ҮГИЙН
БОГИНО ЭГШИГ АВИАНЫ ТОХИРОЛ**

Д. Баасанбат *

Тува хэл судлалын хувьд одоо үед зайлиггүй судалж гүйцэтгэвэл зохих, ард нийтэд танин ойлгуулах тулгамдсан асуудлын нэг бол, монгол- тува хэлний харьцуулсан судалгаа хийх явдал юм. Монгол- тува хэлийг харьцуулан судлахын тулд, хоёр улсын ард түмний түүхийг сөхөн үзэх, эрт эдүгээгийн харилцаа холбоог судлах нь зайлиггүй билээ.

Тувачууд нь өнө эртнээс төв азийн томоохон өндөрлөгүүд болох Тагна, Соён, Сийлхэм, Алтайн нурууны баруун зүүн биеэр нутаглаж байжээ. Зүүн Соён, Тагнын тайгад амьдарч байсан ойн иргэдийн тухай, “Эд нар ой тайгад амьдарч байснаар ийнхүү нэрлэгдэх болсон, гэр орон, майхан гэж мэддэггүй, амьтны арьсан дээлтэй, хонь ба үхрийн оронд уулын үхэр (цаа буга) өсгөж сүүгий нь ууж, махыг нь иднэ. Хонь хариулахыг тэд маш уйтгартай гутамишигт хэрэг гэж үзнэ. Тэр ч байтугай эцэг эх нь охиноо загнахдаа “Чамайг хонь хариулдаг хүний эхнэр болгож өгнө” гэхэд охин нь гоморхон гашиудахдаа өөрийгөө боомилон үхдэг ч байжээ. Уулын үхэрт нуруу ачин, нүүж буусан газартаа модны холтсоор орон барьж амьдардаг. Тэд энэ амьдралаас сайхан амьдрал хаана ч байхгүй гэж үздэг” [Рашид-ад- Дин, 1952, 123] гэж бичжээ. Чингис хаан Монголын нэгдсэн улсыг байгуулсны дараахан буюу 1207 онд Тува аймгийг эрхэндээ оруулж авсан тухай “Монголын нууц товчоо”-нд товч дурдсан байдаг. “Туулай жил (1207 он) Зүчи баруун гарын цэргийг авч Ойрад, Буриад, Барга, Урсууд, Хабаханас, Хомханас, Тува аймгийг оруулаад ...ирэв.” [Монголын Нууц Товчоо, 1990, 208] гэсэн нь ой тайгаар нутаглагч жижиг буурай аймгуудыг баруун гарын цэрэг онцын эсэргүүцэлгүйгээр эзэлж авсан түүхэн баримтыг дурджээ.

Тува аймгуудын уугуул нутгийг Урианхайчуудын хязгаар хэмээн монголчилсоор ирсэн. Одоогийн Алтайн Урианхайчууд бол монголжсон тува нар билээ. Цэнгэлийн тувачууд бид, тэднийг Тангды гэж өнөө хэр нэрлэсээр байгаа нь, тэд Тува улсын

* МУИС-ийн МХСС-ийн Монгол хэлний тэнхим

нутагт орших Тангды (Тагнын) уул хавиас ирснийг нотолном биш үү? Өнөөгийн урианхай нарын өвөө, эмээ нар голдуу тува нэртэй, бөө, удганууд нь өдөр тутмын яриандаа урианхай(монгол) хэлийг хэрэглэвч бөөлөх үедээ тува болчихдог байсныг мэдэх гэрч нар байсаар байна. Буянт сумын уугуул, зурагчин Цэрэндорж, Цэндэв нарын аав Човаа зайран ус цас шиг урианхай хэлтэй мөртлөө, тувагаар бөөлдөг гэж самган нь болох Мөөсөн эмээ манай ээжид ярьж байхыг би чихээрээ сонссон билээ. 1755-1757 онд Манж-хятад-халхын нэгдсэн зэвсэгт хүчний эсрэг боссон Амарсанаагийн 27 отог их цэргийн 17 отог нь дан тувачуудаас бүрэлдэж байсан гэж Содугур Гежсеге хочтой Шөөдүкей-оглу Дагва нагац ярьдаг байсан билээ. [Гагаа.Ч. Уб.2009.х-10.]

Академич Л.Болд эртний түрэг хэлний судлал, жич, монгол хэл ба түрэг хэлний харьцуулсан судалгаа хийж байгаа монгол улсын эрдэмтэн юм. Тэрээр “Уйгар урианхай хэлэнд орсон монгол үг”, “монгол хэлнээс уйгар урианхай хэлэнд орсон үгийн жинг авианы онцлог” зэрэг зохиол бичиж, уйгар урианхай хэлэнд орсон монгол үгийн тухай судалжээ.[Болд.Л. Уб., Хэл зохиол судлал. 1977. XII.76].

Хэлшинжлэлийн ухаанд дэлхийн бүх хэлийг гарлын ба хэв шинжийн талаас нь ангилах хоёр үндсэн арга байдгийн, гарлын ангилал нь төрөл хэлний хүрээнд тухайн хэлнүүдийн авианзүй, үгзүй болон үгийн сан зэрэгт үндэслэж судалгаа хийдэг бол хэв шинжийн ангилал нь төрөл бус хэлнүүдийн хэлзүйд үндэслэж тэдгээр хэлний хэлбэрийн талыг судалдагаараа ялгаатай юм. Тува монгол хэл нь гарал нэгтэй Алтай язгуурын хэл учраас түгээмэл зүй тогтол байхын сацуу өвөрмөц зүй тогтол байгааг бидний судалгаа батлан харуулж байна. “Хоёр хэлний түгээмэл зүй тогтол авиалбарын хувьд бүрэлдэхүүн, бүтэх арга, хувьслаар, үгийн бүтцийн хувьд язгуур+ дагавар+ нөхцөл гэсэн тогтолцоогоор өгүүлбэрийн бүтцийн хувьд SOV гэсэн гишүүний байрлалын хуулиар үгийн сангийн хувьд дундын үгийн бүрэлдэхүүнээр нотлогдоно.” [Баасанбат.Д. 2008.127.]

Харьцуулсан хэл шинжлэлийн онолд удам сурвалжийн харьцаа бүхий хэлнүүдэд авианы тохиролцооны жам хууль оршиж байдаг.

Нийт монгол хэлнүүд нь эгшиг зохицох ёстой боловч ихэнх тохиолдолд хэлний байрлалаар эсвэл уруулын шинжээрээ зохицно. Өөрөөр хэлбэл тэргүүн үеэс хойш орсон эгшгүүд нь тэргүүн үеийн эгшгээс шалтгаалдаг гэсэн үг юм. Тиймээс нэг бол эр, эмээрээ эсвэл уруулаар зохицдог байна. Гэвч эгшиг зохицох ёс нь халх-монгол, буриад-монгол, ойрд-монгол гэх мэт аялгуунууддаа харьцангуй тогтвортой байдаг атлаа монгол, дунсян, дагуур, бао-ань зэрэг хэлэнд эгшиг зохицох ёс тогтворгүй шинжтэй, могол хэлэнд эгшиг зохицох ёс үгүй болжээ. Авианы зохицолд эгшигийн болон гийгүүлэгчийн тохироо гэж хоёр зүйл байна.

Монгол болон тува хэлтнүүдийн хоорондын харилцаа олон зууны туршид үргэлжилсээр ирсэн. Энэ нь тэдгээр хоёр хэлэнд тодорхой хэмжээний утга, дуудлага, дүрсээрээ ижил үгс бий болох нөхцөлийг бүрдүүлжээ.

Монгол улс дахь Тува нарын бичиг үсгийн тухайд гэвэл, 1930 он хүртэл монгол бичиг, 1930-1941 он хүртэл латин бичиг үсэг, тус тус хэрэглэж байгаад, 1941 оноос кирилл үсэг бичигт шилжсэн. Эгийг авианы хувьд:

1. Тува хэл богино (и,е,ү,ө,э,ы,а,у,о), урт ('и, 'е, 'ү, 'ө, ээ, 'ы, 'а, 'у, 'о), хөөмийн (иъ, еъ, үъ, өъ, ыъ, аъ, уъ, оъ) гэсэн эгийг үсэгтэй. [Даваасүрэн. Б. 2005. 114]

2. Хөөмийн эгийг зөвхөн үгийн нэгдүгээр үед тохиолдоно.

3. Богино, урт, хөөмийн эгийг эсрэгцэж утга ялгана. Жишээлбэл: ам нэр, аам савла-, бүүвэйлэ-, аъм морь, адуу гэх мэт.

4. Эгийг зохицох хуультай. Жишээ нь: аъдымга аравыска бидний морьдод, холумну миний гарыг г.м.

Монгол хэлний авиа зүйд уруулын эгийг өөрчлөлт их гарсан. Алс дорнод болон өмнөд, дорнодын тува хэллэгүүд монгол хэлнээс үндэслэлтэй байдаг. Жишээ нь:

тув: херик-эрик,	мон бич: эргэ,	монг:эрэг,
тув: хелезин-элезин,	мон бич: элэсүн,	монг:элс,
тув: хөреге-өреге,	мон бич: эруке,	монг:өрх,
тув: хөреме, өреме,	мон бич: өрүм-э,	монг: өрөм г.м.

Монгол - тува хэлний дундын үгийн богино эгийг авианы тохирлыг хоёр хэлний эгийг авианы бүрэлдэхүүнтэй холбоотойгоор тайлбарлаж болох юм. Иймээс энэ хоёр хэлний эгийг авианы тохирол нэгдүгээрт, бүрэлдэхүүнээсээ хамаарч нийлэх болон, салаалах байдлаар тохирох авианы хуулийн боломж байна. Өөрөөр хэлбэл, бүрэлдэхүүний хувьсалд хоёр хэлний эгийг ерөнхий тохирол нуугдаж байж болох юм. Хоёрдугаарт, хэлний хөгжил, авианы байрлал, хувьслаас хамаарч эгийг авианы янз бүрийн тохирлын хууль ч байж болох байна. Тува хэлний үгийн сан дахь Монгол үгсийн авиазүйн дүр төрхийг судалсны үр дүнд зээлдсэн үгийн орон байр болон цагийн солбицол дээр тодорхойлогдож чадах авианы үзэгдлүүдийг эгийг авианы салбарт “и” эгийг тусгалаар тооцож болно. Түүний нэгдүгээр болон түүнээс хойшихи үгийн уртатгалын зохицол, хамжин шүргэх гийгүүлэгч болон хамарисан гийгүүлэгчийн тусгалаар аванзүйн онцлогийг мэдэх боломжтой. Тухайлбал, монгол бичиг тархсан нутаг дэвсгэрт нэгдсэн нэг дуудах хэлбэр байхгүйгээс болж үгийн дууны төлөв хувьсан өөрчлөгддөг байжээ. Хуучирсан үг хэллэгт үгийн сүүлд ордог [i] нь үгийн эхэнд буюу адагт дуудагддаг байна.

Жишээ нь:

тув: нирвана-ириваан, монбич: нирван, монг:нирваан=нярваан,
тув: дариги, дарийги, мон бич: дар-а экэ, монг: дарь эх гэх мэт.

Мөн ерөнхий утгат нэг үгс нь [и] буюу [ы] үсэг үгийн хойно орж утга төстэй үг болдог. Тува хэлэнд монгол үгс нэлээд хувийг эзэлдэг. Монгол хэлний зарим үг нь түрэг үг боловч, монгол үгтэй утга нэг байдгийг Дж.Клоусон өөрийн тэмдэглэлдээ

тэмдэглэсэн байдаг. Жишээ нь: монгол хэлэнд улс, тува хэлэнд улус гэх мэт. Тийм болохоор энэ үгс монгол хэлнээс гаралтай. Ерөнхийдөө монгол, тува хэл маш адилхан бөгөөд монгол, тува хэл нь түрэг хэлнээс ялгаатай байсан нь уг хэл монгол хэлнээс өмнө оршин тогтнож байжээ. Сибирийн түрэг хэл нь (Алтай, Хакас, Якут) Тува хэлтэй ойролцоо байсан нь монгол үг хэллэгтэй болсныг гэрчилж байна[Татаринцев.Б.И. 1976.]

Л.В.Котвичийн хэлснээр, Монгол хэлний урт үгсийг түрэг хэлтэй харьцуулснаар эртний монгол хэлний хэрэглээнд гийгүүлэгч сэлгээж хэлэгдэх болон, зарим гийгүүлэгч авиа шалтгаанаар ялгаатай дуудагддаг байсан. Иймээс тэдний дараа эгийг бий болсон. Түрэг хэлний нийлмэл эгийгүүдээс гарсан монгол хэлний үгсийн хэсэг бий болсон. Энэ хэсэг үгсээс тува хэлэнд зарим нь байх ба түүнд монгол хэлний зээлдсэн үг хамардаг нь лавтай.

Жишээ нь:

тува-кыргы,	мон бич-кирг-а,	монг-хярга	түрэг-кырк,
угу	уха	ух	уг
хенче	кэнжэ	хэнз	кенч
хилинчек	килинчэ	хилэнц	кылынч
шингээ	шингэ	шингэ	син гэх мэт.

Хоёр хэлний эгийг бүрэлдэхүүнээс хамаарч орчин цагийн монгол -тува хэлний дундын үгэнд эгийг авианы дараах ерөнхий тохирол байна. Жишээ нь:

А $\begin{cases} -а & \text{Ахуйч-агыйжы, Алба- албан, Ажил-ажыл} \\ -у & \text{Будаг-будук, Булаг-булук, Булан-булун, Буурал-буурул, Суварга-сувурга} \\ -уу & \text{Будах-будуур,} \\ -ы & \text{Наадам-наадым} \end{cases}$

Ө — -а Сав-сава

Э $\begin{cases} -э & \text{Эр-эр, эрх-эрге,эрт-эрте,} \\ -ү & \text{Бүргэд- бүргүт, Бүрэн- бүрүн, Бүтэн-бүдүн, Зүтгэл-чүткүл,} \\ -е & \text{Мэх- меге, Бэлгэ- белге, Бэлэг-белек, Бэл- бел, Зэрлэг-черлик,} \\ -и & \text{Бэртэх- бертик} \end{cases}$

О — -а Осол озал, Бодол-бодал, Омог-омак, Онгоц-онгача, Оноо-оона

Ө $\begin{cases} -е & \text{Өртөг-өртег, Өтөг-өдек, Өлөн-өлен, Хөрөнгө-хөренги, Өртөг-өртег} \\ -ү & \text{Өргөн-өргүн, Өрөм-өрүм} \\ -үү & \text{Өргөх-өргүүр} \\ -өө & \text{Мөрий- мөөрей} \end{cases}$

У $\begin{cases} о & \text{Бушуу- божуу, Муж- можу} \\ -ы & \text{Будаа-быдаа, бултах- былдаар, урам-ырма} \end{cases}$

Ү — ө Бөгтөр-бөктүр, Бүлгэм-бөлгүм, Бөмбөг-бөмбүк, Бүлэг-бөлүк,

И — а Архи-арага,
 - аа Арилжаа-араалча
 - ы Ажилч-ажылчы, Ажилчин-ажылчын, Анги-ангы, Занишил-занчыл,
 - ү Өчиг-өчүк

Үүнээс үзвэл монгол — тува хэлний *а, о, е, и, i* таван эгийг авиа бүрэн тохирох ба, монгол хэлний *“а”* эгийг тува хэлний *“и’иу’ы”* эгийгтэй, монгол хэлний *“е”* эгийг тува хэлний *“е, й, i”* эгийгтэй, монгол хэлний *“о”* эгийг тува хэлний *“е, й, йй, ёо”* эгийгтэй, монгол хэлний *“о”* эгийг тува хэлний *“а”* эгийгтэй, монгол хэлний *“i”* эгийг тува хэлний *“а,” “аа,” “ы,” “й”* эгийгтэй, монгол хэлний *“й”* эгийг тува хэлний *“о”* эгийгтэй, монгол хэлний *“и”* эгийг тува хэлний *“о,” “ы”* эгийгтэй тус тус салаалж тохирох хувьсал байна.

Нөгөө талаар эгийг авиа нийлэх тохиолдолд, ихэвчлэн хоёр хэлний уугал үг зонхилж байгаа бол, салаалах тохиолдолд хоёр хэлний уугал үгээс гадна, монгол хэлнээс тува хэлэнд орсон зээлсэн, ормол дундын үгэнд нэлээд тохиолдож байгаа нь ажиглагдаж байна.

Энэ бүх жишээнээс үзвэл тухайн эгийг авиа бүхий л эгийг авиатай сэлгэх хувьсал буй нь мэдэгдэж байгаа боловч, хоёр хэлний ижил эгийг авианы тохирол хамгийн түгээмэл тохиолддог нь мэдэгдэж байна

Монгол хэл болон Тува хэлний хооронд XIII зууны үед хэрэглэж байсан эртний монгол хэлний авиа зүйн үндсэн онцлогууд байдаг бөгөөд энэ нь *“и”*-гийн хувирлын эхний үе бөгөөд, хоёрдугаар хэсэгтээ төгсгөлийн гийгүүлэгч *“н”* авиагаар солигдож *“ж,” “ч”* шуугиант гийгүүлэгчийг хадгалсан байдаг. Монгол тува бичгийн хэлэнд үгийн эхэн дунд *“и”* эгийг ижил байна.

Жишээ нь:

тува: бибжик,	мон бич: бичиг,	монг: бичиг,
илеткел	илэдхэл	илтгэл
килен	килэн	хилэн
чижик	жижигэ	жижиг г.м.

Тува хэлний *“ы”* эгийг нь монгол бичгийн *“и”* болон орчин цагийн монгол хэлэнд *“я”* эгийгтэй, зарим үед *“а”* эгийгтэй дүйдэг.

тува: кыдат	мон бич: китад	монг: хятад
чывар	жибар	жавар
ылгал	илгал	ялгал гэх мэт.

Ихэнх тохиолдолд тува хэл, монгол төрлийн хэлэнд хамаардаг ба *“и”* эгийг эхний үед ороход (дараагийн үеийн эгийгүүд ижилсдэг) орчин үеийн монгол хэлний аялга нь тэгш бус хэмжээнд тодорхойлогддог. Үүний зэрэгцээ монгол хэлнээс зээлсэн

тува хэлэнд “и” эгийг янз янзаар хэлэгддэг. Тэр дундаас ялангуяа “ы”-г дээр үед зээлж авсан үгэнд хувирал харагддаггүй нь баталгаа болж өгч байна. Энэ үйл явц монгол хэлнүүдэд XIII-XIV зуунаас эхэлж XV зуунд төгссөн. Үүний үндсэн дээр эртний зээлж авсан үгсийн тоонд дараах үгсийг оруулж болно.

тув: чыраа, монбич: жируг-а, монг: жороо, калм: жора,
тув: шыда, мон бич: чида, монг: чад-,
тув: шыдараа, мон бич: шитар-а, монг: шатар калм шатр
тув: шыда<чыда, мон бич: жида, монг: жад, калм: жида-<жид, мук:
жида,
тув: чыргал, мон бич: жиргал, монг: жаргал, калм жиргл г.м.

Тува хэлэн дэх авианы хувирал бүхий зээлдмэл монгол үгсийн шууд эх сурвалж нь өнөөгийн монгол хэл, эсвэл монгол бичгийн хэлний эх сэдвүүд ч байж болно. Халх аялгуунд “и” эгийг хувиралтай үг нэлээдгүй байдаг ба хувирсан, хувираагүй хэлбэртэй сэлгэсэн нь монгол хэлний зээлж авсан үгийн шалтгааны эх үүсвэр юм гэж Б.Я.Владимирцов бичсэн. Монгол бичиг ба халх аялгуунаас зээлж авсан үгс монгол хэлний бүрэлдэхүүн хэсэг ийг онцгой хугарал байхгүй ба тува хэлэнд энэ үг бага зэрэг тусгагдсан байгаа юм. Тухайлбал кызыгаар ба ызыгуур гэдэг үгсийн “з” гийгүүлэгч нь эртний монгол хэлний шивэгнэх гийгүүлэгч “ж, дж” бус харин халх аялгууны уруулаар исгэрэх “з, дз” гэж үзэх нь илүү магадлалтай байгаагаар баталж болно.

Нэлээд хожуу зээлж авсан монгол хэлний “и” эгийг хувиралгүй үг тува хэлэнд туссан нь:

тув: чыгза, мон бич: жиса, монг: жас,
тув: хына, мон бич: кина, монг: хяна,
тув: чыгскаал, мон бич: жигсагал, монг: жагсаал,
тув: шылгалда, мон бич: силгалта, монг: шалгалт гэх мэт.

Үүний учир шалтгаан нь тува хэлэн дэх тодорхой тооны үгс эхний задгай үедээ “ы” эгийг агуулдаг ба ийм үгсийн тухайн нөхцөлийн ихэнх нь түрэг хэлний “а”-тай дүйцсэн байдаг. Ямарч эргэлзээгүйгээр ийм төрлийн зээллэг нэлээд хожуу үеийнх бөгөөд “и” эгийг нугарал явагдсаны дараа монгол хэлнээс тува хэлэнд шилжсэн нь тодорхой байна. Гэхдээ хоёрдох үеийн эгийгээс шалтгаалж “и” эгийг балархай болсон нь өөрөө тува хэлэнд явагдсан гэж болох талтайг үндэслэх үндэслэгээ бий. Эхний үеийн эгийг нь балархайлсан зээлдмэл үгийн гарвалд нь “и” оролцож байсан байх тохиолдлоор үүнийг нотолж болно.

Жишээ нь:

тув: бүгдүү, мон бич: битэгүү, монг: битүү гэх мэт.

Энэхүү зохицол хожуу үеийн монгол хэлний эхүүд болон монгол бичгийн хураасан ба зөв бичгийн дүрмийн үндэс хооронд илэрдэг.

тув: шүгүмчүлел, мон бич: сүгүмжилэл, монг: шүүмжлэл,
тув: бүдүгүүлүк<бүдүүлүк, мон бич: бүдүгүлиг, монг: бүдүүлэг.

Эхний үеийн эгшигийн дараагийн үеийн эгшгээс үүдэн балархайших нь илүү эрт үеийнх юм.

тув: чурагай, мон бич: жирухай, монг: зурхай,
тув: чурук, мон бич: жируг, монг: зураг, калм: зург,
тув: чүбзүн, мон бич: жисүн, монг: зүс, калм: зүсн,
тув: чүткү, мон бич: жидкү, монг: зүтгэ, калм: зүтк,
тув: шутку, мон бич: чидху, монг: цутга, калм: цутх гэх мэт.

Ийнхүү дундын үгийн зарим нэгэн онцлогууд дүрсээрээ “и” эгшигийн нугарлыг санагдуулах мэт боловч үнэн хэрэгтээ тува хэлэнд шилжихдээ өртөгдсөн өөрчлөлт байж болох юм. Зээлдсэн үгийн “и” эгшигийг ховор тохиолдолд жишихэд уруулын уйтан эгшигийн өмнө монгол хэлний анхны шинжтэй нь таардаг.

Жишээ нь:

тув: ширийн, мон бич: сирүгүн, монг: ширүүн,
тув: илиир, мон бич: илэгүр, монг: илүүр,
тув: хыды, мон бич: киду, монг: хяд гэх мэт.

Харь хэлнээс зээлдсэн үгэнд уруулын эгшиг монгол хэлний эхний бус үед [и] эгшиг дэвшин ижилсэж ордог. Жишээ нь:

тув: доьичу, мон бич: тобчи, монг: товч
тув: хувура, мон бич: хубира, монг: хувир-г.м.

Энэ бүхнээс эргэцүүлэн үзэхлээр монгол-тува хэлний дундын үгийн богино эгшиг нь хэлний хөгжил, авианы байрлал, хувьслаас хамаарч эгшиг авианд уруулын эгшигийн өөрчлөлт их гарсан, монгол бичиг тархсан нутаг дэвсгэрт, нэгдсэн нэг дуудах хэлбэр байхгүйгээс болж үгийн дууны төлөв хувьсан өөрчлөгдсөн. Хоёр хэлний дундын үгийн эгшиг авианы тохирол нь бүрэлдэхүүнээсээ хамаарч нийлэх болон, салаалах байдлаар тохирох авианы хуулийн боломж байна. Ингээж эгшиг авиа нийлэх тохиолдолд, ихэвчлэн хоёр хэлний уугал үг зонхилж байгаа бол, салаалах тохиолдолд монгол хэлнээс тува хэлэнд орсон зээлсэн, ормол дундын үг нэлээд тохиолдож байгаа нь ажиглагдаж байна.

Дээрх жишээнээс үзвэл тухайн эгшиг авиа, бүхий л эгшиг авиатай сэлгэх хувьсал буй нь мэдэгдэж байгаа боловч, хоёр хэлний ижил эгшиг авианы тохирол хамгийн түгээмэл тохиолддог нь мэдэгдэж байна. Нэлээд хожуу зээлж авсан монгол хэлний “и” эгшигийн хувиралгүй үг тува хэлэнд туссан ба тодорхой тооны үгс эхний задгай үедээ “ы” эгшиг агуулдаг ба ийм үгсийн тухайн нөхцөлийн ихэнх нь түрэг хэлний “а”-тай дүйдэг.

НОМ ЗҮЙ

1. Баасанбат Д (2008), Монгол-манж бичгийн хэлний дундын үг, Улаанбаатар.
2. Базаррагчаа М (1987), Монгол хэлний авиа сэлгэх ёс, Улаанбаатар.
3. Болд Л (1977), Монгол хэлнээс уйгар урианхай хэлэнд орсон үгсийн эгшиг авианы онцлог. Улаанбаатар, Хэл зохиол судлал XII.8.
4. Гагаа Ч (2009), Тува өвгөний дурдатгал, Улаанбаатар.
5. Даваасүрэн Б (2005), Алтай овгийн хэлнүүд, Улаанбаатар.
6. Зоригту.Го (2000), Монгол төрлийн хэл ба түрэг төрлийн хэлний үгсийн харьцуулсан судлал, Өв.Мо.,
7. Исхаков Ф.Г (1961), Грамматика тувинского языка. Фонетика и морфология, Москва.
8. Монголын Нууц Товчоо (1990), Улаанбаатар.
9. Монгуш Д.А (1963), Формы прошедшего времени изъявительного наклонение в тувинском языке, Кызыл.
10. Пунцаг Т (1985), Монгол Тува-Орос толь, Улаанбаатар.
11. Монгуша Д.А (1980), Русско-тувинский словарь /под ред.. Москва.
12. Татаринцев.Б.И (1976), Монгольское языковое влияние на тувинскую лексику, Кызыл.
13. Татаринцев.Б.И (1987) , Смысловые связи и отношения слов в тувинском языке, Москва.
14. Төмөртоого Д (2002), Монгол хэлишинжлэлийн онол, түүхийн асуудлууд, Улаанбаатар.
15. Жамьян Г (1970), Тод үсгийн зөв бичгийн дүрэмд урт эгшигийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудалд, Улаанбаатар, Монгол судлал. №-7.
16. Тенишева Э.Р (1968), Тувинско-русский словарь, Москва.
17. Ууганбаяр М (2008), Тува хэлнээс уйгар урианхай хэлэнд орсон үгсийн эгшиг авианы онцлог, Улаанбаатар, МУИС, МХСС, эиб. №-29. 138-142-р тал.
18. Ууганбаяр М (2008), Тува хэлэн дэх монгол зээллэг үгсийн авиан зүйн онцлог, Улаанбаатар, МУИС.МХСС.ЭШБ №-XXIX(300) х-138-142.
19. Хертек Я.Ш (1974), Фразеология современного тувинского языка, Кызыл.

РЕЗЮМЕ

В данной статье рассматриваются вопросы о составе звуков, способе их образования, месте и разветвленном соответствии эволюции межсезовых слов монгольского и тувинского языков. Эти явления демонстрируются соответствующими примерами. А также здесь освещаются в сравнительном плане выводы и мхехия ученых- исследователей этой отрасли. Было показано то, что как изменяется монгольское гласное “и” в тувинском языке.